



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Тогтоолын хэрэгжилтийг түдгэлзүүлэх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.2, Захиргааны ерөнхий хуулийн 96 дугаар зүйлийн 96.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 415 дугаар тогтоолоор “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар томилогдож, 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс ажил хүлээн авсан Б.Баттогтох нь контракт байгуулах саналыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаас контракт байгуулагдаагүй, мөн тус үйлдвэрийн газрын Үйлдвэрчний эвлэлийн хороо болон ажиллагсдаас Б.Баттогтоход холбогдуулж удаа дараа ирүүлсэн гомдол, санал, хүсэлт, шаардлага, ажлын хэсгийн дүгнэлтийг судалж шийдвэрлэх, үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг явуулах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс уг тогтоолын хэрэгжилтийг түр түдгэлзүүлсүгэй.

2.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулж “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газарт төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн В.Дарханбаатарыг 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн түр томилсугай.

3.В.Дарханбаатараар тус үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг хавсран гүйцэтгүүлж, санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсэг зурах, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрхийг олгосугай.

4.В.Дарханбаатарт тус үйлдвэрийн газрын захирлын албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлсийг зохих журмын дагуу тооцож олгохыг “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газарт зөвшөөрсүгэй.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001525